



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 11 сарын 13 өдөр

Дугаар A/678

Арвайхээр

Отрын штаб байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн “а” дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл ажлын хүрээнд 2018-2019 оны өвөл, хавар өөрийн аймгийн сум хооронд болон зэргэлдээ аймгийн нутагт отроор өвөлжиж байгаа малчдад эрүүл, мэнд, нийгэм, төрийн үйлчилгээг зохицуулах “Аймгийн отрын штаб”-ыг байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Отроор өвөлжиж, хаваржиж байгаа малчдын талаар холбогдох судалгаа, мэдээллийг нарийвчлан гаргаж, малчдын сургуулийн насны хүүхдийг тухайн очсон сумдын сургуульд хамруулах, хүн, мал эмнэлэг, соёл, холбоо мэдээлэл, төрийн үйлчилгээгээр үйлчлэх асуудлыг сумдын удирлагуудтай хамтран зохицуулж, малчдыг тав тухтай өвөлжүүлж, хаваржуулах арга хэмжээ авч ажиллахыг “Аймгийн отрын штаб” (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Аймгийн отрын штабын ажил үүргээ гүйцэтгэхэд зарцуулах түлш шатахуун, хоол, холбоо мэдээлэл болон бусад үйл ажиллагаатай холбогдон гаргах зардлыг аймгийн Засаг даргын нөөц сан болон Монгол Улсын Засгийн газраас шийдвэрлэсэн нэмэлт зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА




Г.ГАНБОЛД

011101467

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2012 оны 11 дугаар сарын 13-ны өдрийн А/678 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ОТРЫН ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

Штабын дарга: И.Доржсүрэн -Аймгийн Засаг даргын орлогч

Штабын орлогч дарга: С.Цэдэнбалжир – Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд: Д.Энхбат – Аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газрын дарга

Д.Шивааннүрдэв –Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга

Г.Баясгалан –Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

О.Ганбат – Аймгийн Цагдаагийн газрын дарга

С.Дуламсүрэн - Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга

Ж.Пүрэвсүрэн – Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын дарга

Ч.Гүнсэнхорол – Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Б.Оюунчимэг – Аймгийн Засаг даргын дэргэдэх Ус цаг уур, орчны шинжилгээний албаны дарга

А.Нямдаваа – Аймгийн Засаг даргын дэргэдэх Мал эмнэлгийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Б.Цэнгэл –Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн албаны дарга